



Олоо хоног тутмын хэвлэл
1 сны 08 дугаар сарын 25
№32 /701/

ХИШААГА

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын
Засгийн газрын
тогтоол

1377

Монгол Улсын
Засгийн газрын
тогтоол

1380

Сургалтын төрийн сангийн
санхүүжилтээр дэлхийн
шилдэг их сургуульд
суралцуулах журам батлах
тухай

Мэргэжлийн сургалт,
үйлдвэрлэлийн төв байгуулах
тухай

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

338.	Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 212	1369
339.	Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай	Дугаар 214	1370
340.	Ой тэмдэглэх тухай	Дугаар 215	1374
341.	Ой тэмдэглэх тухай	Дугаар 216	1376
342.	Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр дэлхийн шилдэг их сургуульд суралцуулах журам батлах тухай	Дугаар 217	1377
343.	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв байгуулах тухай	Дугаар 218	1380

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 7 дугаар
сарын 6-ны өдөр

Дугаар 212

Улаанбаатар
хот

Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний үнэ өөрчлөгдсөнтэй холбогдуулан төлбөргүй зорчих иргэдийн нөхөн олговорт нэмж шаардагдах хөрөнгийг төсвийн багцдаа тусган санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаяр, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж нарт даалгасугай.

2. Нийслэлийн нийтийн тээврийн байгууллагуудыг дизелийн түлшээр хангах, түлш нийлүүлэх үйл ажиллагаанд хяналт тавьж, газрын тосны бүтээгдэхүүн импортлогч аж ахуйн нэгжтэй урт хугацааны гэрээ байгуулан зохистой түвшинд нөөц бүрдүүлж ажиллахыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригтод даалгасугай.



3. Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлж байгаа байгууллагуудын сахилга хариуцлагыг дээшлүүлэх, санхүүгийн чадавхийг сайжруулах, өр төлбөрийг барагдуулах, тээвэрчдийн нийгмийн асуудал, ажлын байрны нөхцөлийг сайжруулах талаар тодорхой хөтөлбөр боловсруулж, цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Г.Мөнхбаяр нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Ч.ХҮРЭЛБААТАР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 7 дугаар
сарын 6-ны өдөр

Дугаар 214

Улаанбаатар
хот

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 5.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. "Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг батлах тухай" Засгийн газрын 1995 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 241 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтад дор дурдсан агуулга бүхий 594-609 дэх заалт нэмсүгэй:

594

Дурсгалын нэр:

Зохиогч:

Холбогдох он цаг:

Хадгалагдаж буй газар:

Дурсгалын шинж байдал:

ТАМГА, ХАЙРЦГИЙН ХАМТ

Нэр үл мэдэгдэх бүтээгч

XVII зуун буюу 1662-1722 оны үе

Богд хааны ордон музей

Хүрэн өнгийн зандан мод, гууль, зэс, мөнгө. "Бүхнийг ялагч очир баригч Занабазарын тамга" гэсэн эвхмэл монгол бичигтэй.

Тамга: Өндөр 10 см, суурь 5.2 x 5.2 см, жин 275 гр

Хайрцаг: Өндөр 11 см, суурь 6.2 x 6.5 см, жин 370 гр

Хувийн дугаар: 24-8-102



595

Дурсгалын нэр:
Зохиогч:
Холбогдох он цаг:
Хадгалагдаж буй газар:
Дурсгалын шинж байдал:

Г.ЗАНАБАЗАРЫН ДЭЭЛ
Нэр үл мэдэгдэх бүтээгч
XVII зуун буюу 1662-1722 оны үе
Богд хааны ордон музей
Өнгө бүрийн торгон утсан хээтэй,
хүрэн пүүсүү гадартай, цэнхэр пүүсүү
дотортой, 6 ширхэг гуулин товчтой.
Урт 149 см, өргөн 100 см
Хувийн дугаар: 24-8-102

596

Дурсгалын нэр:
Зохиогч:
Холбогдох он цаг:
Хадгалагдаж буй газар:
Дурсгалын шинж байдал:
Хувийн дугаар:

Г.ЗАНАБАЗАРЫН ХҮҮХЭД АХУЙН
ДЭЭЛ
Нэр үл мэдэгдэх бүтээлч
XVII зууны дунд үе
Өвөрхангай аймаг, Хархорин
сум, Эрдэнэ зуу музей
Улаан шар торго, даавуу, минжний
арьс. 100 см x 122 см
02-4-1, 5/400

597

Дурсгалын нэр:
Зохиогч:
Холбогдох он цаг:
Хадгалагдаж буй газар:
Дурсгалын шинж байдал:
Хувийн дугаар:

Г.ЗАНАБАЗАРЫН ХҮҮХЭД АХУЙН
ХУВРАГ ДЭЭЛ
Нэр үл мэдэгдэх бүтээлч
XVII зуун
Өвөрхангай аймаг, Хархорин сум,
Шанхын Баруун хүрээ хийд
Торго, даавуу. 136 см x 98 см
2008-8

598

Дурсгалын нэр:
Зохиогч:
Холбогдох он цаг:
Хадгалагдаж буй газар:
Дурсгалын шинж байдал:
Хувийн дугаар:

Г.ЗАНАБАЗАРЫН ХҮҮХЭД АХУЙН
НОМЫН ХУВЦАС
Нэр үл мэдэгдэх бүтээлч
XVII зуун
Өвөрхангай аймаг, Хархорин сум,
Шанхын Баруун хүрээ хийд
Торго, улаан хүрэн тэрэм. 77 см x 33 см
2008-9

599

Дурсгалын нэр:

ХОС ЦАН (Г.ЗАНАБАЗАРЫН ХҮҮХЭД
АХУЙДАА ХЭРЭГЛЭЖ БАЙСАН)



Зохиогч:	Нэр үл мэдэгдэх бүтээлч
Холбогдох он цаг:	XVII зуун
Хадгалагдаж буй газар:	Өвөрхангай аймаг, Хархорин сум, Шанхын Баруун хүрээ хийд
Дурсгалын шинж байдал:	Цан (металл) Голч 20 см, жин 720 гр
Хувийн дугаар:	2008-10
600	
Дурсгалын нэр:	Г. ЗАНАБАЗАРЫН ГУТАЛ
Зохиогч:	Нэр үл мэдэгдэх бүтээлч
Холбогдох он цаг:	1640 оны орчим
Хадгалагдаж буй газар:	Дундговь аймаг, Цагаандэлгэр сум, Баруун Чойрын хийд
Дурсгалын шинж байдал:	Эсгий, торго, даавуу, таар, шир. Өндөр 26.5 см, түрүүний өргөн 13 см, улны өргөн 20 см
Хувийн дугаар:	-
601	
Дурсгалын нэр:	Г.ЗАНАБАЗАРЫН ДӨШ
Зохиогч:	Г.Занабазар
Холбогдох он цаг:	XVII зууны сүүл XVIII зууны эхэн үе
Хадгалагдаж буй газар:	Монголын Үндэсний музей
Дурсгалын шинж байдал:	Ган, алт шармал. 11 см x 16 см x 16 см, жин 8.650 гр
Хувийн дугаар:	Ү.62-1-44
602	
Дурсгалын нэр:	БУРХНЫ ХЭВ
Зохиогч:	Г.Занабазар
Холбогдох он цаг:	XVII зууны сүүл XVIII зууны эхэн үе
Хадгалагдаж буй газар:	Монголын Үндэсний музей
Дурсгалын шинж байдал:	Гууль. 13.5 см x 12 см x 11 см, жин 3.800 гр
Хувийн дугаар:	Ү.76-16-1
603	
Дурсгалын нэр:	СУВАРГА
Зохиогч:	Г.Занабазар
Холбогдох он цаг:	XVII зууны сүүл XVIII зууны эхэн үе
Хадгалагдаж буй газар:	Монголын Үндэсний музей
Дурсгалын шинж байдал:	Гууль, алт шармал. 10 см x 11 см x 11 см, жин 1.700 гр
Хувийн дугаар:	Ү.82х-9-5

- 604
Дурсгалын нэр: Г.ЗАНАБАЗАРЫН ХЭРЭГЛЭЖ
БАЙСАН ЗАВЪЯА
Зохиогч: Нэр үл мэдэгдэх бүтээлч
Холбогдох он цаг: XVII зууны сүүл XVIII зууны эхэн үе
Хадгалагдаж буй газар: Монголын Үндэсний музей
Дурсгалын шинж байдал: Мөнгөлсөн ган цутгамал.
26 см х 37 см, амсрын голч 12.5 см,
жин 2.520 гр
Хувийн дугаар: Y.63-3-60
- 605
Дурсгалын нэр: Г.ЗАНАБАЗАРЫН АЯНЫ ТОГОО,
ТОГООНЫ ШИРМЭЛ УУТ, ШҮҮРЭН
ШАНАГА
Зохиогч: Нэр үл мэдэгдэх бүтээлч
Холбогдох он цаг: XVII зууны сүүл XVIII зууны эхэн үе
Хадгалагдаж буй газар: Монголын Үндэсний музей
Дурсгалын шинж байдал: Аяны тогоо: Мөнгөлсөн ган.
Өндөр 23 см, голч 30 см, жин 2.635 гр
Ширмэл уут: даавуу, сур. 23 см х 30 см
Шүүрэн шанага: ган, урт 25 см,
халбаганы голч 12 см, жин 215 гр
Хувийн дугаар: Y.63-3-59
- 606
Дурсгалын нэр: Г.ЗАНАБАЗАРЫН АЛГАНЫ ДАРДАС
Зохиогч: -
Холбогдох он цаг: XVII зуун
Хадгалагдаж буй газар: Дүрслэх урлагийн музей
Дурсгалын шинж байдал: Хадаг, зос.
"Занабазарын мутрын дардас" гэсэн
түвд бичигтэй. 55 см х 35 см.
Хувийн дугаар: 76.16.767
- 607
Дурсгалын нэр: Г.ЗАНАБАЗАРЫН ЦАМЦ
Зохиогч: Нэр үл мэдэгдэх бүтээлч
Холбогдох он цаг: XVII зуун
Хадгалагдаж буй газар: Дүрслэх урлагийн музей
Дурсгалын шинж байдал: Өлзий хээтэй шар торгон гадартай,
ногоон туяатай цэнхэр даавуун
дотортой. 69 см х 166 см
Хувийн дугаар: 87.01.05



608
 Дурсгалын нэр: Г.ЗАНАБАЗАРЫН ЗУРГААДАЙ ТАЯГ
 Зохиогч: Нэр үл мэдэгдэх бүтээлч
 Холбогдох он цаг: XVII зуун
 Хадгалагдаж буй газар: Гандантэгчилэн хийд
 Дурсгалын шинж байдал: Урт 116 см, толгойн өргөн 5 см,
 суурийн өргөн 3 см
 Хувийн дугаар:

609
 Дурсгалын нэр: Г.ЗАНАБАЗАРЫН БОЙВОГ (гутал)
 Зохиогч: Нэр үл мэдэгдэх бүтээлч
 Холбогдох он цаг: XVII зуун
 Хадгалагдаж буй газар: Гандантэгчилэн хийд
 Дурсгалын шинж байдал: Булигар
 "Анхдугаар Богдын ерөөсөн бойвог"
 гэсэн түвд бичигтэй.
 Улны урт 25,5 см, өлмийн өргөн 10 см,
 өсгийн өргөн 6,5 см, түрүүний өргөн 19,5 см
 Хувийн дугаар:

МОНГОЛ УЛСЫН
 ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
 УХААНЫ САЙД

Ё.ОТГОНБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 7 дугаар
 сарын 6-ны өдөр

Дугаар 215

Улаанбаатар
 хот

Ой тэмдэглэх тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Төрийн хошой шагналт, урлагийн гавьяат зүтгэлтэн Донровын Намдагийн мэндэлсний 100 жилийн ойг 2011 онд тэмдэглэсүгэй.

2. Ойн арга хэмжээг зохион байгуулах үүрэг бүхий комиссын бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.



3. Ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээнд шаардагдах 31.5 (гучин нэгэн сая таван зуун мянган) сая төгрөгийг Монгол Улсын 2011 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд тусган санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд С.Баярцогтод даалгасугай

4. Ойд бэлтгэх, тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэхийг Зохион байгуулах комисст даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД**

Ё.ОТГОНБАЯР

САНГИЙН САЙД

С.БАЯРЦОГТ

Засгийн газрын 2011 оны 215 дугаар
тогтоолын хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ХОШОЙ ШАГНАЛТ,
УРЛАГИЙН ГАВЪЯАТ ЗҮТГЭЛТЭН Д.НАМДАГИЙН
МЭНДЭЛСНИЙ 100 ЖИЛИЙН ОЙН АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН
БАЙГУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН**

Дарга -Боловсрол, соёл, шинжлэх ухааны дэд сайд
Ч.Куланда

Гишүүд: Улсын Их Хурлын гишүүн З.Алтай
(зөвшилцсөнөөр);

-Соёл, урлагийн хорооны мэргэжилтэн
О.Сундуй;

-Драмын эрдмийн театрын захирал
Д.Цэрэнсамбуу;

-“Түгээмэл” дээд сургуулийн захирал
Ү.Хүрэлбаатар;

-Төрийн шагналт зохиолч Д.Батбаяр.

Нарийн бичгийн дарга -Монголын зохиолчдын эвлэлийн
хорооны дарга Г.Мөнхцэцэг



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 7 дугаар
сарын 6-ны өдөр

Дугаар 216

Улаанбаатар
хот

Ой тэмдэглэх тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Төрийн шагналт, академич Дамдины Пэрлээгийн мэндэлсний 100 жилийн ойг 2011 онд тэмдэглэсүгэй.
2. Ойн арга хэмжээг зохион байгуулах үүрэг бүхий комиссын бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.
3. Ойн арга хэмжээнд шаардагдах 30.5 (гучин сая таван зуун мянган) сая төгрөгийг Монгол Улсын 2011 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд тусган санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд С.Баярцогтод даалгасугай
4. Ойд бэлтгэх, тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэхийг Зохион байгуулах комисст даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД**

Ё.ОТГОНБАЯР

САНГИЙН САЙД

С.БАЯРЦОГТ

Засгийн газрын 2011 оны 216 дугаар
тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ШАГНАЛТ, АКАДЕМИЧ Д.ПЭРЛЭЭГИЙН МЭНДЭЛСНИЙ 100 ЖИЛИЙН ОЙН АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	-Шинжлэх ухааны академийн дэд ерөнхийлөгч Т.Дорж
Дэд дарга	-Археологийн хүрээлэнгийн захирал Д.Цэвээнжав; -Түүхийн хүрээлэнгийн захирал С.Чулуун.
Гийгүүр:	- Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Шинжлэх ухаан, технологийн газрын дарга

Ө.Сүхбаатар ;

-Монголын Үндэсний музейн захирал

Ж.Саруулбуян;

-Монгол Улсын Их сургуулийн Түүхийн

судалгааны хүрээлэнгийн захирал Ж.Болдбаатар;

-Монгол Улсын Их сургуулийн Нийгмийн

шинжлэх ухааны сургуулийн захирал Г.Эрдэнэбаяр;

-“Чингис хаан” дээд сургуулийн захирал Х.Лхагвасүрэн;

-Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын

хүрээлэнгийн төслийн удирдагч А.Очир;

-Д.Пэрлээгийн зээ охин Т.Оюун

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 7 дугаар
сарын 6-ны өдөр

Дугаар 217

Улаанбаатар
хот

**Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр
дэлхийн шилдэг их сургуульд суралцуулах
журам батлах тухай**

Боловсролын тухай хуулийн 28.1.14-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр дэлхийн шилдэг их сургуульд суралцуулах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаярт, журмыг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг жил бүр улсын төсөвт тусгаж байхыг Сангийн сайд С.Баярцогтод тус тус үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД**

Ё.ОТГОНБАЯР

САНГИЙН САЙД

С.БАЯРЦОГТ



Засгийн газрын 2011 оны 217 дугаар
тогтоолын хавсралт

СУРГАЛТЫН ТӨРИЙН САНГИЙН САНХҮҮЖИЛТЭЭР ДЭЛХИЙН ШИЛДЭГ ИХ СУРГУУЛЬД СУРАЛЦУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын иргэдийг Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр дэлхийн шилдэг их сургуульд инженер, технологийн чиглэлээр бакалаврын шатны сургалтад суралцуулахад энэхүү журмыг баримтална.

1.2. Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага (цаашид "яам" гэнэ) нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд нийцүүлэн тухайн жилд гадаад орны их сургуулиудад Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр инженер, технологийн чиглэлээр суралцуулах мэргэжлийн чиглэл, суралцах хүний тоог тогтоож, жил бүрийн 2 дугаар сард багтаан яамны вэб хуудсаар нийтэд зарлана.

1.3. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн дэлхийн шилдэг их сургуулиудын зэрэглэл тогтоодог байгууллагуудын нэг болох Томсон Ройтерсийн инженер, технологийн чиглэлийн дэлхийн шилдэг сургуулиудын зэрэглэлийн эхний 50-д багтсан сургуулийн нэрсийг яамны вэб хуудсанд байршуулна.

Хоёр. Суралцагчид тавигдах шаардлага

2.1. Математик, физик, хими, биологи, мэдээлэл зүйн улсын олимпиадад 1, 2, 3 дугаар байр эзэлсэн, эсхүл боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр эдгээр чиглэлийн олон улсын олимпиадад оролцсон Монгол Улсын иргэн дараахь шаардлагыг хангасан нөхцөлд Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр суралцах эрхтэй:

2.1.1. Монгол Улсын магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуульд зохих журмын дагуу элсэн суралцах эрх авсан буюу 1, 2 дугаар курст 3.5-аас доошгүй голч дүнтэй суралцаж байгаа иргэн энэ журмын 1.3-т заасан их сургуульд тогтоосон мэргэжлийн чиглэлээр үндсэн ангид суралцах эрх авсан байх;

2.1.2. энэ журмын 1.3-т заасан их сургуульд яамнаас тогтоосон мэргэжлийн чиглэлээр үндсэн ангид хувийн зардлаар суралцаж байх.

2.2. Монгол Улсын Засгийн газрын шугамаар гадаадын их, дээд



сургуульд тэтгэлэгтэйгээр суралцах эрх авсан буюу суралцаж байгаа бол энэ тэтгэлэгт хамрагдахгүй.

Гурав. Бүртгэх, шийдвэр гаргах

3.1 Суралцагч нь дараахь бичиг баримтыг бүрдүүлж яаманд бүртгүүлнэ:

3.1.1. өргөдөл (яамнаас гаргасан маягтын дагуу);

3.1.2. их сургуулийн үндсэн ангид суралцах эрх олгосон тухайн сургуулийн албан ёсны захидлын эх хувь болон хуулбар (Тайлбар: Элссэн сургуулиасаа сургалтын төлбөрийн болон бусад хөнгөлөлтийг авах нөхцөл хангасан бол түүнийг баталгаажуулсан байна);

3.1.3. их, дээд сургуульд элсэн суралцах эрхийн бичиг болон түүний хуулбар, суралцаж байгаа сургуулийн тодорхойлолт, дүнгийн жагсаалтын эх хувь;

3.1.4. бүрэн дунд боловсролын гэрчилгээ, дүнгийн хавсралтын эх хувь болон түүний хуулбар;

3.1.5. эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамрагдаж холбогдох бичиг баримтыг бүрдүүлсэн байна.

3.2. Журмын шаардлагыг бүрэн хангасан иргэнийг Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр суралцуулах тухай шийдвэрийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаргана.

3.3. Сургалтын төрийн сан нь боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас баталсан загварын дагуу суралцагчтай гэрээ байгуулна. Гэрээнд суралцах мэргэжлийн чиглэл, сургалтын хугацаа, төлбөр зэрэг асуудлыг тодорхой тусгасан байна. Суралцагчийн сурлагын дүн, тухайн сургуулийн дүрэмд заасан болзол, шаардлагыг ханган суралцаж байгаа талаархи сургуулийн тодорхойлолтыг үндэслэн хичээлийн жил бүрийн төгсгөлд гэрээг сунгах асуудлыг шийдвэрлэнэ.

3.4. Суралцагч нь сургуулиа төгсөөд эзэмшсэн мэргэжлийн дагуу эх орондоо эргэн ирж, 5-аас доошгүй жил үр бүтээлтэй ажилласан байна.

Дөрөв. Бусад зүйл

4.1. Өргөдөл гаргагч нь энэ журамд заасан шаардлагыг хангаагүй, бичиг баримтаа дутуу, эсхүл хуурамчаар бүрдүүлсэн бол Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр суралцуулахгүй.

4.2. Энэ журмыг хэрэгжүүлэх явцад гарсан маргааныг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 7 дугаар
сарын 6-ны өдөр

Дугаар 218

Улаанбаатар
хот

Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв байгуулах тухай

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 14.1, Иргэний хуулийн 31 дүгээр зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Орхон болон Булган аймагт Хөдөө аж ахуйн мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийг тус тус байгуулсугай.

2. Төв аймгийн Эрдэнэ сум болон Сэлэнгэ аймгийн Сант суман дахь мэргэжлийн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн бүтцэд байгаа мэргэжлийн сургалттай хэсгийг тусгаарлан Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв болгон өөрчлөн байгуулсугай.

3. Шинээр болон өөрчлөн байгуулагдсан Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийн байр, эд хөрөнгийг төрийн өмчид шилжүүлэх ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн хороо (Д.Сугар)-нд даалгасугай.

4. Шинээр болон өөрчлөн байгуулагдсан Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийн сургалтын орчныг сайжруулж, багшлах боловсон хүчнээр хангах асуудлыг улсын төсөв, хандивлагч болон хувийн хэвшлийн дэмжлэг оролцоотойгоор зохион байгуулж ажиллахыг Сангийн сайд С.Баярцогт, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаяр нарт даалгасугай.

5. Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд сургах мэргэжлийн чиглэл, хяналтын тоог хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчийн захиалгын дагуу тогтоож, захиргааны болон мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Мэргэжлийн боловсрол, сургалтын газарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД**

Ё.ОТГОНБАЯР

Хаяв:

"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн редакци.

Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: turiin_medecelel@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хувдас 0.75

Индекс: 14003

